



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

ШУУРХАЙ ШТАБЫН ЦАХИМ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын хурал 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 15:00 цагт гишүүдийн 100 хувийн ирцтэй хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хурлыг Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын дарга Р.Дагва даргалж, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалж, халдварын тархалтын “Шар түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцэж холбогдох асуудлаар үүрэг чиглэл өгөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад

1.1. Засгийн газар, Улсын Онцгой комиссоос Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн цуцалж, халдварын тархалтын “Шар түвшин”-д шилжсэнтэй холбогдуулан “Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасныг баримтлан халдвар хамгааллын дэглэмийг сахиж, амны хаалт тогтмол зүүж, гараа ариутган, дархлаа сэргээх нэмэлт тунд ажилчдаа бүрэн хамруулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг уриалж ажиллах.

Хоёр. Дүүргийн Онцгой комиссын Шуурхай штабын дарга, дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт

2.1. Засгийн газар, Улсын Онцгой комиссоос Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн цуцалж, халдварын тархалтын “Шар түвшин”-д шилжүүлэн, өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг хариу арга хэмжээг сулруулахгүй, хяналт хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах;

2.2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг хариу арга хэмжээний тандалтын үйл ажиллагаанд дайчлагдан ажиллаж байгаа төр, хувийн хэвшлийн байгууллагын хүн хүч, техник хэрэгслийг үргэлжлүүлэн хэвийн ажиллуулах;

2.3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгон, халдварын тархалтын “Шар түвшин”-тэй уялдуулан боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангуулах;

2.4. Дүүргийн харьяа байгууллага, аж ахуй нэгжүүд, иргэдэд чиглэсэн коронавируст халдварын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

2.5. Өрх, дүүргийн Эрүүл мэндийн төвийн тандалт, хариу арга хэмжээний багийн үйл ажиллагаанд салбар дундын оролцоог хангах, бүхий л талын дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах.

Гурав. Нийслэлийн Боловсролын газарт

3.1. Ерөнхий боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хичээл сургалтын үйл ажиллагаа танхимаар хичээллэж эхэлсэнтэй холбогдуулан халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан хяналт тавьж, холбогдох албан тушаалтныг Шуурхай штабт томилж мэдээллээр хангаж ажиллах;

3.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хариу арга хэмжээний багийн гишүүд хүүхдийн ирцийн байдалд өдөр бүр хяналт тавин, дүгнэлт хийж, холбогдох хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх, анги танхимын өдөр тутмын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд тогтмол хяналт тавих;

3.3. Сургууль, цэцэрлэгийн хичээлийн дундуур, завсарлагаа, хичээл тарсны дараа болон гал тогоо, ариун цэврийн өрөөнд агаар сэлгэлт, халдваргүйжүүлэлт хийх, анги, танхимд агаар цэвэршүүлэгчийг тогтмол ажиллуулах;

3.4. Анги удирдсан багш нар коронавируст халдвар батлагдсан хүүхдийн ар гэртэй тогтмол холбоотой байх, халдвар батлагдсанаас хойш шинж тэмдэггүй бол 5, хөнгөн хэлбэрээр өвдсөн бол 7, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн бол эмнэлгээс гарснаас хойш 3 хоногийн дараа хичээлд нь ирүүлэх;

3.5. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч нь Коронавируст халдвар авч сурагч, хүүхэд ойрын хавьтал болсон тохиолдолд гэрийн ажиглалтад 5 хоног байлгах.

Дөрөв. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба,

Нийслэлийн Онцгой байдлын газар,

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,


Нийслэлийн Байгаль орчны газар,

Нийслэлийн Мал эмнэлгийн газар,

Дүүргийн Онцгой комиссын дарга нарт

4.1. Улсын Онцгой комиссын 2022 оны 02 дугаар хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн хүрээнд ой хээрийн түймэр, малын гоц халдварт өвчин, шар усны үер, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээ, үзлэг шалгалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулан хүн хүч, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах.

ШУУРХАЙ ШТАБЫН
ДАРГА



Р.ДАГВА